



МОНГОЛБАНК
МОНГОЛ УЛСЫН ТӨВ БАНК

МӨНГӨ, САНХҮҮГИЙН СТАТИСТИК

Танилцуулга
2019 оны 11 дүгээр сар


Улаанбаатар
2019



1 Мөнгөний нийлүүлэлт

Мөнгөний нийлүүлэлт буюу M2 мөнгө өмнөх оны мөн үеэс 9.8 хувиар өсч 20.5 их наяд төгрөгт хүрлээ. M2 мөнгөний жилийн өсөлтийн 5.8 нэгж хувийг төгрөгийн хадгаламж, 3.1 нэгж хувийг төгрөгийн харилцах, 1.9 нэгж хувийг гадаад валютын хадгаламж, -0.8 нэгж хувийг гадаад валютын харилцах бүрдүүлсэн байна.


Зураг 1-1: M2 мөнгө өмнөх оны мөн үеэс 9.8%-иар нэмэгдсэн байна.



Эх сурвалж: Монголбанк

Өмнөх сартай харьцуулахад мөнгөний нийлүүлэлт 8.8 тэрбум төгрөг буюу 0.04 хувиар өсчээ.

Зураг 1-2: M2 мөнгө өмнөх сараас 8.8 тэрбум төгрөгөөр өссөн байна.




Эх сурвалж: Монголбанк

Тодруулбал, улс болон хувийн байгууллагын төгрөгийн харилцах, иргэдийн гадаад валютын хадгаламж өсчээ. Харин улсын болон бусад санхүүгийн байгууллагын төгрөгийн хадгаламж, иргэдийн гадаад валютын хадгаламж өсч, улсын байгууллагын төгрөгийн харилцах буурсан байна.

Нийт хадгаламжийн хэмжээ 14.0 их наяд төгрөг байгаа ба 84.4 хувь буюу 11.8 их наяд төгрөг нь иргэдийн, 15.6 хувь буюу 2.2 их наяд төгрөг нь байгууллагын хадгаламж байна. Нийт хадгаламжийн 23.3 хувь нь гадаад валютын хадгаламж байна. Үүнээс иргэдийн хадгаламжийн 23.5 хувийг, байгууллагын хадгаламжийн 22.2 хувийг гадаад валютын хадгаламж бүрдүүлж байна.

Зураг 1-3: Нийт хадгаламж өмнөх оны мөн үеэс 11.4%-иар өсч 14.0 их наяд ₮-т хүрчээ.




Эх сурвалж: Монголбанк

M2 мөнгөний нийлүүлэлтийг байршуулалт талаас нь авч үзвэл, Төв банк болон хадгаламжийн байгууллагуудын дотоод цэвэр актив (ДЦА)-ын дүн 17.8 их наяд төгрөг, гадаад цэвэр актив (ГЦА)-ын дүн 2.6 их наяд төгрөгтэй тус тус тэнцэж

байна. Өмнөх оны мөн үетэй харьцуулбал M2 мөнгөний өсөлтийн 14.2 нэгж хувийг ГЦА, -4.4 нэгж хувийг ДЦА бүрдүүлж байна. ГЦА-ын өсөлтөд Төв банкны гадаад цэвэр актив нэмэгдсэн нь нөлөөлсөн бол ДЦА-ын бууралтад Төв банкин дахь Засгийн газрын хөрөнгө нэмэгдсэн болон банкуудын зээл олголт багассантай холбоотой байна.

Зураг 1-4: M2 мөнгөний жилийн өсөлтийн дийлэнх хэсгийг ГЦА-ын өсөлт бүрдүүлж байна.



Эх сурвалж: Монголбанк

2 Банкуудын зээл

2.1 Зээлийн өсөлт

Банкуудын зээлийн үлдэгдэл өмнөх оны мөн үеэс 8.6 хувиар өсч 18.0 их наяд төгрөгт хүрсэн байна. Үүнээс иргэдэд олгосон зээлийн үлдэгдэл 8.8 хувиар өсч 9.3 их наяд төгрөгт, хувийн байгууллагын зээл 8.0 хувиар өсч 8.5 их наяд төгрөгт хүрчээ.

Зураг 2-1: Нийт зээлийн үлдэгдэл 18.0 их наяд төгрөгт хүрч жилийн 8.6 хувиар өсөв.




Эх сурвалж: Монголбанк

Нийт зээлийн үлдэгдлийн 11.7 хувь буюу 2.1 их наяд төгрөгтэй тэнцэх хэмжээний валютын зээл байна.

2.2 Зээл олголт, эргэн төлөлт

Тайлант сард шинээр олгосон зээл өмнөх сараас 368.3 тэрбум төгрөгөөр, эргэн төлөгдсөн зээл 272.8 тэрбум төгрөгөөр тус тус буурчээ.

Зураг 2-2: Тайлант сард 1,650 тэрбум төгрөгийн зээл олгогдож, 1,704 тэрбум төгрөгийн зээл эргэн төлөгдлөө.




Эх сурвалж: Монголбанк

Шинээр олгосон зээлийн 7.9 хувь буюу 131.0 тэрбум төгрөгийг гадаад валютаар олгожээ.

2.3 Чанаргүй зээл

Чанаргүй зээлийн 81.7 хувийг, хугацаа хэтэрсэн зээлийн 77.0 хувийг хувийн байгууллагын зээл бүрдүүлжээ.

Зураг 2-3: Нийт зээлийн 10.6% нь чанаргүй зээл, 5.3% нь хугацаа хэтэрсэн зээл байна.




Тайлбар: * үйл ажиллагаа явуулж буй 13 банкаар
Эх сурвалж: Монголбанк

Чанаргүй зээлийн үлдэгдэл 1,911.8 тэрбум төгрөгт хүрч өмнөх сартай харьцуулахад 10.8 тэрбум төгрөгөөр буурсан байна. Чанаргүй зээлийн 17.8 хувь нь гадаад валютгийн зээл байна.

Чанаргүй зээлийн 23.1 хувийг уул уурхай, 20.9 хувийг боловсруулах, 12.3 хувийг барилга, 8.5 хувийг үл хөдлөх, 8.3 хувийг худалдааны салбарын зээл эзэлж байна.

Зураг 2-4: Чанаргүй зээлийн 81.7% хувийн байгууллагын, 17.4% иргэдийн зээл байна.




Эх сурвалж: Монголбанк

2.4 Хувийн байгууллагын зээл

Хувийн байгууллагын зээлийн үлдэгдэл тайлант сард өмнөх сараас 5.9 тэрбум төгрөгөөр буурчээ.

Зураг 2-5: Хувийн байгууллагын зээлийн үлдэгдлийн дийлэнх хувийг худалдаа, барилга, боловсруулах болон уул уурхайн салбарын зээл бүрдүүлэв.



Эх сурвалж: Монголбанк

Хувийн байгууллагын зээлийн сарын өөрчлөлтийг эдийн засгийн үйл ажиллагааны салбараар ангилан харуулбал, боловсруулах салбарын

зээл 31.5 тэрбум, мэдээлэл холбооны салбарын зээл 15.6 тэрбум, барилгын салбарын зээл 12.9 тэрбум төгрөгөөр тус тус өсч, худалдааны салбарын зээл 37.2 тэрбум, хөдөө аж ахуйн салбарын зээл 10.5 тэрбум төгрөгөөр буурсан байна.

Тайлант сард хувийн байгууллагад 844.7 тэрбум төгрөгийн зээл шинээр олгогдсоны 12.7 хувь буюу 107.7 тэрбум төгрөгтэй тэнцэх зээл гадаад валютаар олгогджээ.

Зураг 2-6: Худалдаа, боловсруулах болон уул уурхай салбарт дийлэнх зээл олгогдсон байна.




*Цахилгаан хий, усан хангамж, газар тариалан, мэдээлэл холбоо, санхүү даатгал, мэргэжлийн ШУ, захиргаа, төрийн удирдлага, боловсрол, эрүүл мэнд гэх мэт салбарууд.
Эх сурвалж: Монголбанк

2.5 Иргэдийн зээл

Иргэдийн зээлийн үлдэгдэл өмнөх сараас 28.9 тэрбум төгрөгөөр буурсан байна.

Зураг 2-7: Иргэдийн зээлийн 38% (МИК-д шилжүүлсэн багцыг оруулснаар)-ийг орон сууцны зээл, 33%-ийг цалин тэтгэврийн зээл бүрдүүлэв.




Эх сурвалж: Монголбанк

Үүнээс, ипотекийн зээл 21.7 тэрбум, худалдааны зээл 14.9 тэрбум төгрөгөөр тус тус өссөн бол, харин цалин, тэтгэврийн зээлийн үлдэгдэл 61.1 тэрбум, автомашины зээл 8.1 тэрбум, хадгаламж барьцаалсан зээл 7.9 тэрбум төгрөгөөр тус тус буурсан байна.

Тайлант сард иргэдэд 756.1 тэрбум төгрөгийн зээл шинээр олгогдсоны 3.1 хувь буюу 23.2 тэрбум төгрөгийн зээл гадаад валютаар олгогджээ.

Зураг 2-8: Иргэдийн зээлийн ихэнх хувийг хадгаламж барьцаалсан, цалин тэтгэвэр, картын зээл эзэлж байна.



*ХАА, газар тариалан, боловсруулах, цахилгаан хий, усан хангамж, тээвэр агуулах, үйлчилгээ, мэдээлэл холбоо, мэргэжлийн ШУ, захиргаа, төрийн удирдлага, боловсрол, эрүүл мэнд гэх мэт салбарууд.


Эх сурвалж: Монголбанк

2.6 ЖДҮ-ийн зээл

ЖДҮ эрхлэх зориулалтаар аж ахуйн нэгж болон иргэдэд олгосон нийт зээлийн үлдэгдэл 4,035 тэрбум төгрөг байна.

Үүний 32.4 хувийг худалдааны салбарт, 15.1 хувийг боловсруулах үйлдвэрлэлийн салбарт, 12.4 хувийг барилгын салбарт, 8.5 хувийг үйлчилгээний салбарт тус тус олгосон байна.

Зураг 2-9: ЖДҮ эрхлэх зориулалтаар ААН болон иргэдэд олгосон зээлийн 32 хувийг худалдааны салбар бүрдүүлж байна.




Эх сурвалж: Монголбанк

3 Ипотекийн зээл

2019 оны 11 дугаар сарын байдлаар 95,958 зээлдэгч нийт 4.6 их наяд төгрөгийн ипотекийн зээлтэй байна. Үүнээс хөтөлбөрийн эх үүсвэрээр 71,423 зээлдэгч 3.4 их наяд төгрөгийн зээл авчээ.

Зураг 3-1: Ипотекийн зээлийн үлдэгдлийн жилийн өсөлт 4.3%-д хүрэв.




Эх сурвалж: Монголбанк

Ипотекийн зээлийн үлдэгдлийн 74.0 хувь нь хөтөлбөрийн хүрээнд, 20.8 хувь нь банкуудын өөрийн эх үүсвэрээр, 5.2 хувь нь бусад эх

үүсвэрээр олгосон зээл байна. Нийт ипотекийн зээлийн 16.9 хувь буюу 771.8 тэрбум төгрөгийн зээл орон нутагт ногдож байна.

Зураг 3-2: Нийт зээлийн 16.9% буюу 771.8 тэрбум төгрөг орон нутагт ногдож байна.



Эх сурвалж: Монголбанк

Орон нутгийн ипотекийн зээл¹-ийн 77.8 хувь нь хөтөлбөрийн хүрээнд, 19.1 хувь нь банкны өөрийн эх үүсвэрээр, 3.2 хувь нь бусад эх үүсвэрээр олгогдсон байна.

Зураг 3-3: Өмнөх сараас хугацаа хэтэрсэн зээл 3.9 тэрбум төгрөгөөр өсч, чанаргүй зээл 1.3 тэрбум төгрөгөөр буурчээ.




Эх сурвалж: Монголбанк

Нийт ипотекийн зээлийн үлдэгдлийн 95.5 хувь нь хэвийн, 2.6 хувь нь хугацаа хэтэрсэн, 1.9 хувь нь чанаргүй

¹ Уг зээл нь орон нутгийн банкны салбараас олгосон бус худалдан авсан орон сууцны байршлаар тооцсон.

зээл байна. Чанаргүй ангилалд шилжсэн ипотекийн зээлийн 60.3 хувийг банкуудын өөрийн эх үүсвэрээр олгосон зээл, 37.8 хувийг хөтөлбөрийн зээл, 1.9 хувийг бусад эх үүсвэрийн зээл эзэлж байна. Тайлант сард 947 зээлдэгчид 62.6 тэрбум төгрөгийн ипотекийн зээл шинээр олгосон бөгөөд үүний 47.2% хувийг хөтөлбөрийн эх үүсвэрээр санхүүжүүлсэн байна.


Зураг 3-4: Тайлант сард шинээр 947 зээлдэгчид ипотекийн зээл шинээр олгожээ.



Эх сурвалж: Монголбанк

Тухайн сард шинээр олгосон ипотекийн зээлийн жигнэсэн дундаж хүү өмнөх оны мөн үеэс 0.7 нэгж хувиар өсч, өмнөх сараас 1.1 нэгж хувиар буурч 11.5 хувьд хүрсэн байна.

Зураг 3-5: Шинээр олгосон ипотекийн зээлийн жигнэсэн дундаж хүү өмнөх оны мөн үеэс 1.1 нэгж хувиар буурчээ.




Эх сурвалж: Монголбанк

4 Хүү

4.1 Шинээр татсан хадгаламж


2019 оны 11 дүгээр сард нийт шинээр татсан төгрөгийн хадгаламжийн жигнэсэн дундаж хүү (ЖДХ) 11.0 хувь, гадаад валютын хадгаламжийн ЖДХ 4.3 хувьд хүрч төгрөгийн ЖДХ өмнөх оны мөн үеэс 0.7 нэгж хувиар буурав.

Зураг 4-1: Шинээр татсан төгрөгийн хадгаламжийн хүү 0.7 нэгж хувиар буурав.



Эх сурвалж: Монголбанк

Зураг 4-2: Шинээр татсан хугацаатай хадгаламжийн хүү 11.3%, хугацаагүй хадгаламжийн хүү 6.2% байна.



Эх сурвалж: Монголбанк


4.2 Шинээр олгосон зээл

Тайлант сард нийт шинээр олгосон төгрөгийн зээлийн ЖДХ 17.0² хувь,

² Хөтөлбөрийн зээл, Хөгжлийн банкны санхүүжилтийн зээлийн дүнгүүдийг оруулаагүй болно.


гадаад валютын ЖДХ 10.7 хувьд хүрч, төгрөгийн зээлийн хүү өмнөх оны мөн үеэс 0.2 нэгж хувиар буурав.

Зураг 4-3: Шинээр олгосон төгрөгийн зээлийн хүү 17.0% байна.



Эх сурвалж: Монголбанк

Зураг 4-4: Шинээр олгосон нийт зээлийн хүү өмнөх оноос 0.2 нэгж хувиар буурав.



Эх сурвалж: Монголбанк


Иргэдэд 756.1 тэрбум төгрөгийн зээл олгосноос дийлэнх нь буюу 72.8 хувь нь 2 жил хүртэлх хугацаатай байна.

4.3 Үлдэгдлээрх хадгаламж

Нийт төгрөгийн хадгаламжийн үлдэгдэлд ЖДХ 11.5 хувьтай байгаа нь өмнөх оны мөн үеэс 0.6 нэгж хувиар буурчээ. Харин нийт гадаад валютын хадгаламжийн ЖДХ 4.8 хувьтай байна. Хадгаламжийн үлдэгдэлд ЖДХ иргэдийн төгрөгийн хадгаламжийн хувьд 11.6 хувь, гадаад валютын хадгаламжийн хувьд 4.8 хувьтай байгаа бол хувийн байгууллагын

төгрөгийн хадгаламжийн хувьд 10.8 хувьтай байна.

Зураг 4-5: Үлдэгдлээр жигнэсэн төгрөгийн хадгаламжийн хүү 11.5% байна.




Эх сурвалж: Монголбанк

4.4 Хүүний зөрүү

Тухайн сард шинээр олгосон төгрөгийн зээл болон тухайн сард шинээр татсан төгрөгийн хадгаламжийн хүүний зөрүү 2019 оны 11 дүгээр сарын байдлаар 6.0 нэгж хувь байна.

Зураг 4-6: Хадгаламж, зээлийн хүүний зөрүү өмнөх оноос 0.4 нэгж хувиар өсчээ.




Эх сурвалж: Монголбанк

4.5 Зээлийн үлдэгдэл

Төгрөгийн зээлийн үлдэгдэлд ЖДХ 16.9 хувь, гадаад валютын зээлийн ЖДХ 10.6 хувьтай байна. Үүнээс

иргэдийн төгрөгийн зээлийн үлдэгдлийн ЖДХ 17.8³ хувьтай, гадаад валютын зээлийн ЖДХ 12.7 хувьтай байна. Хувийн байгууллагын зээлийн ЖДХ 15.6 хувьтай, гадаад валютын зээлийн хүү 10.5 хувьтай байна. Нийт төгрөгийн зээлийн ЖДХ өмнөх оны мөн үеэс 0.4 нэгж хувиар буурсан үзүүлэлттэй байна.


Зураг 4-7: Иргэдийн зээлийн үлдэгдлийн хүү 0.6 нэгж хувиар буурав.



Эх сурвалж: Монголбанк

Зээлийн үлдэгдлийн дийлэнхийг 2-5 жилийн хооронд төлөгдөж дуусах зээлүүд эзэлж байна.

Зураг 4-8: Зээлийн үлдэгдэл, хугацаагаар



Эх сурвалж: Монголбанк


³ Хөтөлбөрийн зээлийг оруулаагүй тооцсон болно.

5 Инфляци

5.1 Улсын инфляци

Хэрэглээний үнийн улсын индекс 2019 оны 11 дүгээр сарын байдлаар жилийн 5.2 хувь, сарын инфляци -0.4 хувь байна.

Зураг 5-1: Улсын жилийн инфляци 5.2 хувьтай байна.



Эх сурвалж: УСХ

Жилийн инфляцийг авч үзвэл, хүнсний барааны үнийн өсөлт нь мах, махан бүтээгдэхүүний үнийн өсөлтөөр тодорхойлогдож байгаа бол хүнснээс бусад барааны өсөлтөд хувцас, бөс бараа болон орон сууц, ус, цахилгаан, түлшний бүлгийн үнийн өсөлт нөлөөлсөн байна.


5.2 Улаанбаатар хотын жилийн инфляци

Улаанбаатар хотын хэрэглээний үнийн индекс 11 дүгээр сарын байдлаар 5.0 хувь байгаа ба 2.7 нэгж хувийг хүнснээс бусад бараа, 2.3 нэгж хувийг хүнсний барааны үнийн өсөлт бүрдүүлж байна.

Хүнсний барааны бүлгийн үнэд мах, махан бүтээгдэхүүн болон будааны үнийн өсөлт, хүнснээс бусад барааны үнэд хувцас, бөс барааны үнийн өсөлт нөлөөлжээ. Харин тээврийн бүлгийн

үнэ буурсан байна. Өмнөх сартай харьцуулахад УБ хотын хэмжээнд 1.0 хувийн дефляцитай байна. Үүний -1.04 нэгж хувийг хүнсний бараа, 0.04 нэгж хувийг хүнснээс бусад барааны үнийн өсөлтөөр тайлбарлагдаж байна.


Зураг 5-2: УБ хотын жилийн инфляци 5.0 хувь



Эх сурвалж: УСХ

Хүнснээс бусад барааны үнэ өсөхөд хувцас, бөс барааны үнийн өсөлт голлон нөлөөлсөн бол хүнсний барааны үнэ буурахад мах, махан бүтээгдэхүүний бууралт нөлөөлжээ.

Зураг 5-3: УБ хотын сарын инфляци дефляцитай байна.




Эх сурвалж: УСХ

6 Төгрөгийн гадаад валюттай харьцах ханш

6.1 Ам.долларын ханш

Төгрөгийн ам.доллартай харьцах ханш сарын эцсийн байдлаар 2,715.2 төгрөгт хүрсэн нь өмнөх сарын эцсээс 0.5 хувиар суларсан үзүүлэлт байна. Тайлант сарын дундаж ханш нь 2,705.3 төгрөг байв.

Зураг 6-1: Төгрөгийн ам.доллартай харьцах ханшийн өөрчлөлт.




Эх сурвалж: Монголбанк

6.2 Хятадын юанийн ханш

Төгрөгийн юаньтай харьцах сарын эцсийн ханш өмнөх сараас суларч 386.4 төгрөг байв. Тухайн сарын хамгийн бага ханш нь 383.7 төгрөг байсан бол хамгийн өндөр ханш нь 387.0 төгрөг байлаа.

Зураг 6-2: Төгрөгийн юаньтай харьцах ханшийн өөрчлөлт.



Эх сурвалж: Монголбанк